

2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Дэлхийн эдийн засаг

Ковид-19-ийн цар тахлын 3 дахь жил сайн муу олон мэдээтэй эхэлж байна. Тухайлбал, эдийн засгууд сэргэж эхэлсэн, дэлхийн хүн амын 61 хувь нь ядаж нэг тунд хамрагдсан, түүхий эдийн үнэ өсөж хөгжиж буй орнуудын эдийн засагт эерэг дам нөлөө үзүүлсэн сайн мэдээнүүдийг дурдаж болох юм.

Ковид-19-ийн шинэ хувилбарын тархалтаас үүдэн дэлхийн болон томоохон улсуудын эдийн засгийн 2022 оны төсөөлөл 0.2-0.5 хувиар буурч байна.

Муу мэдээ гэвэл Ковид-19-ийн шинэ хувилбар Омикрон дэлхий даяар хурдтай тархаж буй нь сэргэж буй эдийн засгийг дахин удаашруулах эрсдэлтэй байна.

График 1: 2022 оны өсөлтийн таамаглал, хувь



Эх сурвалж: Дэлхийн Банк

Улмаар 2021 онд 5.1 хувь гарахаар хүлээгдэж буй дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 4.1 хувь болж удаашрах юм.¹ Эрдэмтэд омикроны идэвхтэй үеийг богино гэж тооцоолж байсан ч эдийн засагт үзүүлэх нөлөө нь хүчтэй байна.

Улмаар улс орнууд хилээ хааж, нийлүүлэлт доголдож барааны үнэ нэмэгдсэнээр инфляц өсөх гол хүчин зүйл болов. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасралтын индекс Ковид-19 тахлын өмнөх 2019 оны 8-р сар болон цар тахлын үеийн 2021 оны 8-р сарын хооронд дөрөв дахин нэмэгдсэн байна. Үр дүнд нь компаниудын ашгийн хэмжээ, иргэдийн худалдан авах чадвар буурснаар эдийн засаг шинжээчдийн хүлээж байсан шиг хурдтай өсөхгүй. БНХАУ “Ковидгүй” бодлого мөн

нийлүүлэлтэд нөлөөлнө. 2022 оны эхний хагас жилд тээврийн үнэ өндөр хэвээр байх боловч хэрэглэгчдийн худалдан авалт тогтворжиж, компаниуд нийлүүлэлтийн шинэ суваг эрэлхийлснээр үнэ буурах хүлээлттэй б

График 3: Нийлүүлэлтийн гинжин хэлхээний индекс



Эх сурвалж: Дэлхийн Банк

Олон улсын геополитикийн бодлого, ОХУ-н Газпром компанийн нийлүүлэлт, Европын улс орнуудын эрс хүйтэн өвөл, сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийн хомсдол болон БНХАУ-н нүүрсний эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор эрчим хүчний үнэ 2021 онд огцом нэмэгдсэн. Энэ хандлага 2022 оны эхний хагаст үргэлжлэх төлөвтэй байна. Эдийн засаг сэргэж хилийн хорио тавигдсанаар эрчим хүч болон хүнс, хүнсний бүтээгдэхүүний үнэ тогтворжих боловч инфляцтай холбоотой үнэт металлын үнэ өсөх хандлагатай байна.

График 2: Түүхий эдийн үнийн индекс




Эх сурвалж: Дэлхийн Банк

Инфляц өсөж байгаа гол шалтгаан бол цар тахлын үеийн үед төв банкуудын баримталсан тэлэх мөнгөний бодлого юм. Бодлогын хүү бага үед мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэнээр

¹ 4.3 хувийн хүлээлтээс буурч 4.1 хувь болсон. Дэлхийн Банкны “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлан

эдийн засаг халж инфляц дэлхий даяар нэмэгдэв. 2022 онд шийдвэр гаргагчид мөнгөний бодлогыг өөрчлөх хэрэгтэй гэж үзэж байгаа. Тухайлбал, АНУ-н Төв Банк 2022 онд мөнгөний нийлүүлэлтээ өдөрт 30 тэрбум ам.доллараар багасгаж улмаар 2022 оны 3-р сард бүрэн зогсоох шийдвэр гаргав.

График 4: АНУ-н Төв Банкны бодлогын хүүний хүлээлт




Эх сурвалж: Америкийн Төв Банк

Мөн 2022, 2023 онд бодлогын хүүг тус бүр гурав, 2024 онд хоёр удаа нэмэхээ мэдэгдээд байна. Үр дүнд нь бонд болон хөрөнгийн зах зээлд савалгаа үүсгэх магадлалтай ба ялангуяа өрийн хэрэгслийн үнэ унаж, ам.долларын ханш нэмэгдэнэ. Энэ нь эргээд ам.долларын өрийн хэрэгсэлтэй хөгжиж буй орнуудад өрийн дарамт үзүүлэх эрсдэлтэй.

Монгол Улсын эдийн засаг

График 5: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Сангийн Яам, Дэлхийн Банк, ОУВС

Гэвч Ковид-19-ийн шинэ хувилбарууд хүчтэй тархаж, дараагийн давалгааг үүсгэж, улмаар улс орнууд хөл хорионы арга хэмжээ авч

эхэлж байгаатай холбогдуулан Дэлхийн Банкнаас 2022 оны 1-р сард өмнөх төсөөллөө бууруулж Монгол Улсын эдийн засгийг 2021 онд 3.5 хувь, 2022 онд 5.1 хувь, харин 2022 онд сэргэж 6.2 хувь өснө хэмээн таамаглаж байна.

Төсвийн орлого

2022 оны төсвийн орлогыг 16.4 их наядын дүнтэй (ДНБ-ий 35.1 хувь) баталсан нь түүхэн дээд хэмжээ болов. Нийт орлогын 26 хувь уул уурхайн салбараас төвлөрүүлэх аж. Гэвч төсвийн орлого уг хэмжээндээ хүрэхгүй байж болзошгүй байна.

2022 оны төсөвт нүүрсний үнийг 130-140 ам.доллар хэмээн таамагласан нь олон улсын байгууллагуудын төсөөллөөс 15-38 хувиар өндөр байна.

График 6: Нүүрсний үнэ ба төсөөлөл, ам.доллар/тн



Эх сурвалж: Дэлхийн Банк, Сангийн Яам, EIA

Мөн нийт 36.7 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр хэмжээтэй тэнцүү байна. 2021 онд 20.5 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд цар тахалтай холбоотойгоор хил гааль хаагдаж тоо хэмжээний тасалдал гарч төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй байх өндөр эрсдэлтэй байна. Мөн энэ хэмжээний нийлүүлэлтийг хийх хүчин чадал одоогоор байхгүй нь нүүрсээ зөөх зам баригдаж дуусаагүйтэй холбоотой.²

Ялангуяа олон нийлүүлэгчтэй болсон БНХАУ-ын коксжих нүүрсний импортын зохих хэсгийг урьдын адил манай талаас хангахад онцгой анхаарах шаардлага тулгараад байна. Харин Сангийн Яамны 2022 оны зэсийн үнийн төсөөлөл Дэлхийн Банкныхтай ойролцоо байна.

² 2016-2020 онд нийт нүүрсний экспортын 52.3 хувь буюу 83.4 сая тонныг Таван толгойгоос Гашуунсухайт боомтоор гаргажээ.

График 7: Зэсийн үнэ ба төсөөлөл, ам.доллар/тн



Эх сурвалж: Дэлхийн Банк, Сангийн Яам

Монгол Улс 2022 онд 36 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн нь сүүлийн 5 жилд хамгийн их нүүрс экспортолсон, хөл хориогүй 2019 оны дүнтэй адилхан байна. Түүхий эдийн нийт экспортын 90-өөс илүү хувийг эзэлдэг БНХАУ 2022 онд “Ковидгүй” бодлого баримталж байна.

График 8: Нүүрсний экспортын хэмжээ, сая тонн



Эх сурвалж: Сангийн Яам

Шалтгаан нь эдийн засгаа дэмжих, мөн 2-р сард болох Өвлийн олимпийн наадам, болон 11-р сард болох БНХАУ-ын Коммунист намын 20-р хурлыг³ хойшлуулахгүй хийх бэлтгэл ажлуудтай холбоотой юм.

Инфляц

Хилийн боомтын хязгаарлалтаас үүдэлтэй импортын хүнсний барааны үнийн өсөлт, тээврийн зардлын өсөлттэй холбоотой махны үнийн өсөлт зэрэг нь ирэх оны эхний хагас хүртэл үргэлжлэх төлөвтэй байна.


Нэгт, нүүрсний үнийг 130-140 ам.доллар хэмээн төлөвлөсөн нь олон улсын шинжээчдийн хүлээлтээс 15-38 хувиар өндөр байна. Дэлхийн Банкны зүгээс нүүрсний үнэ түүхэн дээд түвшиндээ хүрч, улмаар эрэлт

саарч, нийлүүлэлт тогтворжсоноор үнэ буурах хүлээлттэй байна.

Инфляцын 80 хувийг импортын бараа, хүнс болон шатахууны үнэ зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай бүтээгдэхүүнүүд эзэлж байгаа нь инфляц богино хугацаанд буурахгүй байх магадлалтайг харуулж байна.

Улмаар 2022 оны сүүлийн хагасаас үнийн өсөлт тогтворжиж инфляц алгуур буурах хүлээлттэй байна.

График 9: Инфляцын таамаглал




Эх сурвалж: Монгол Банк

Вакцинжуулалт

Дотоодын эдийн засаг хэр хурдтай сэргэх нь улс орнууд хүн амынхаа хэдэн хувийг вакцинжуулж байгаатай шууд холбоотой байгаа нь хэдийн хурдан вакцинжуулалтаа хийсэн улсын эдийн засаг цаашид илүү хурдан сэргэх төлөвтэй байгааг харуулж байна.

График 10: Улс орнуудын вакцинжуулалт, 2022.01



Эх сурвалж: Дэлхийн Банк


Гадаад өр

2021 оны 6-р сард Сангийн Яам нэг тэрбум ам.долларын 3.5 хувийн хүүтэй “Century” бондыг олон улсын зах зээлээс амжилттай босгож 2022, 2023 онуудад төлөгдөх Чингис, Гэрэгэ бондын төлөлтийг хэсэгчлэн төлөхөөр

³ Хурлын бэлтгэл ажил 2022 оны 3-р сараас эхэлнэ.

болсон нь төлбөрийн тэнцэлд ирэх дарамтыг бууруулав. 5.125 хувийн хүүтэй Чингис бонд, 5.825 хувийн хүүтэй Гэрэгэ бондыг хэсэгчлэн 4.45 хувийн хүүтэй 2031 онд төлөх 500 сая ам.доллар болон 2027 онд 3.5 хувийн хүүтэй төлөх 500 сая ам.доллараар дахин санхүүжүүлсэн нь 2021, 2022 онд 45.6 сая ам.долларын хүүгийн зардлыг хэмнэжээ.

График 11: Гадаад бондын хэмжээ, сая ам.доллар




Эх сурвалж: Дэлхийн Банк

Газрын тосны импорт

Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ 2020 оны 10-р сард баррель нь 40 ам.доллар байсан бол 2022 оны 1-р сард 87 ам.доллар болж 2 дахин нэмэгдээд байна.

График 12: Газрын тосны үнэ, ам.доллар/баррель



Эх сурвалж: ОУВС

Монгол Улс 2020 онд 1.66 сая тонн дизель түлш, бензинийг 698 сая ам.доллараар импортолж байсан бол 2021 онд үнийн өсөлтийн улмаас 1.56 сая тонныг 981 сая ам.доллараар импортолжээ. Цаашид үнэ үргэлжлэн өсч 100 ам.доллар давна хэмээн Голдмэн Саксаас таамаглаад байна. Энэ тохиолдолд нийт түлшний импорт дор хаяж 300 гаруй сая ам.доллараар нэмэгдэж болзошгүй бөгөөд энэ нь төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд сөргөөр нөлөөлөх юм.

График 13: Нийт түлшний импорт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Дүгнэлт:

- Омикроны тархалт ихэссэнээр дэлхийн эдийн засгийн сэргэлт хүлээгдэж байснаасаа удаахрах эрсдэлтэй байна.
- БНХАУ “Ковидгүй” бодлого баримталж, 2022 онд хилээ бүрэн нээх магадлал бага байна. Улмаар экспорт төлөвлөж буй хэмжээндээ хүрэхгүй байх эрсдэлтэй.
- Нүүрсний үнэ 2022 онд буурах төлөвтэй байгаа нь төсвийн орлого буурж болзошгүйг илтгэж байна.
- Нүүрсний үнэ буурч, БНХАУ хилээ хааж болзошгүй үед нүүрсээ тээвэрлэх төмөр зам бэлэн биш тул төсвийн орлого тасалдах өндөр эрсдэл байна.
- 2022 онд инфляц 12 хувьд хүрч магадгүй байгаа нь төгрөгийн ханш сулрах, тодорхойгүй байдал үүсгэх замаар санхүүгийн салбарт эрсдэл үүсгэж болзошгүй.
- Монгол Улс нийт иргэдээ вакцинжуулсан түвшнээрээ дээгүүр явж байгаа хэдий ч омикроны тархалт нэмэгдсэнээр эдийн засгийн үйл ажиллагаа эргээд зогсох, удаахрах эрсдэлтэй байна.
- Газрын тосны үнэ өсөх эрсдэлтэй байгаа нь импортын зардлыг нэмж төлбөрийн тэнцэлд дарамт учруулж болзошгүй.

МICS нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг олон нийтэд хүргэн ажилладаг бөгөөд энэхүү судалгаа нь зөвхөн судалгаанд зориулагдсан болно.

И-мэйл: micc@research.mn

Улаанбаатар хот 2021 оны 1-р сар